

COURSE: INTRODUCTION TO INFORMATION SYSTEM

Lecture 9: Midterm 1

Шалгалтын үргэлжлэх хугацаа: 40 минут

1. Federal Express (FedEx) логистик, хүргэлтийн хамгийн том компани юм. Хэрэглэгчдэд илүү сайн үйлчилгээг санал болгохын тулд мэдээллийн системээр хэрэглэгчдийн өгөгдлийг цуглуулан хэрэглэгчдийн сегментжүүлж тус бүрт ямар үйлчилгээ, бүтээгдэхүүн санал болгох талаар шийдэр гаргалт хийх ХХХ модулыг хөгжүүлсэн байна. ХХХ модуль нь тус компаний мэдээллийн системийн аль төрөлд хамаарах вэ?
 - A) Ажил гүйлгээ боловсруулах систем
 - B) Удирдлагын мэдээллийн систем
 - C) Байгууллагын нөөцийн удирдлагын систем (ERP)
 - D) Мэдлэгийн менежментийн систем
2. Мэдээллийн системийн тухай ойлголтод Wikipedia ямар мэдээллийн системийн жишээ болох вэ?
 - A) Хувийн мэдээллийн систем
 - B) Бүлгийн мэдээллийн систем
 - C) Байгууллагын мэдээллийн систем
 - D) Ажил гүйлгээ боловсруулах систем
3. нь мэдээллийн системтэй шууд ажиллан үр дүнгүүдээ авч ажилладаг.
 - A) Системийн шинжээч
 - B) Өгөгдлийн сангийн администратор
 - C) Системийн хөгжүүлэгч
 - D) Эцсийн хэрэглэгчид
4. Санхүү эрхэлсэн дэд захирал улирал бүр орлого зарлагын тайлан, мөнгөн урсгалын тайлан авах шаардлагатай байдаг байна. Энд ямар мэдээллийн системийг ашиглах шаардлагатай вэ?
 - A) Шийдвэр гаргалтад туслах систем
 - B) Удирдлагын мэдээллийн систем
 - C) Байгууллагын нөөцийн удирдлагын систем
 - D) Ажил гүйлгээ боловсруулах систем
5. Үйлдвэрлэлийн компани бүх бизнесийн нэгж, хэсгүүдийн үйл ажиллагааг нэдсэн системд оруулан зохион байгуулах саналтай байгаа бол доорх системүүдийг алийг нь та санал болгох вэ?
 - A) Шийдвэр гаргалтад туслах систем
 - B) Ажил гүйлгээ боловсруулах систем
 - C) Удирдлагын мэдээллийн систем
 - D) Байгууллагын нөөцийн төлөвлөлтийн систем
6. Хувцасны сүлжээ дэлгүүр бүтээгдэхүүн бүрийнхээ борлуулалтыг салбарын байрлалын хамт хадгалдаг байна. Менежерүүд энэ мэдээллийг байгууллагын ашгийг тооцоолох, бүтээгдэхүүний хэрэгцээг мөрдөх, хамгийн түгээмэл загвар, материал нь аль нь болохыг тодорхойлоход ашигладаг байна. Энэ нь чанартай мэдээллийн ямар шинж чанарын жишээ болох вэ?
 - A) Хөрвөх чадвар
 - B) Уялдаа холбоо бүхий
 - C) Баталгаатай
 - D) Нарийвчилсан
7. Системийн тухай зөв, оновчтой тодорхойлолт аль нь байна вэ?
 - A) Орцыг хүлээн авч боловсруулан гарцыг бий болгох замаар хамтдаа ажиллаж байгаа өөр хоорондоо уялдаа холбоотой бүрэлдэхүүн хэсгүүдийн цогц бүрдэл
 - B) Зорилгодоо хүрэхээр явж байгаа эсэхийг тодорхойлохын тулд эргэх холбог хянаж, үнэлж дүгнэх үйл ажиллагаа
 - C) Тэмдэгт, тоо, үсэг, дүрс, зураг зэрэг дижитал хэлбэрт байгаа төрөл бүрийн мэдээллийн эх үүсвэр
8. Аль нь мэдээллийн системийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд вэ?
 - A) Орц, гарц, боловсруулалт, хадгалалт, түгээлт
 - B) Хүмүүс, техник хангамж, програм хангамж, өгөгдөл, сүлжээ
 - C) Компьютерууд, сүлжээнүүд, хэвлэгчүүд, эцсийн хэрэглэгчид, хөгжүүлэгчид
 - D) Аль нь ч биш
9. нь шийдвэр гаргах процессын үе шатуудад менежерүүдийг шаардлагатай мэдээллээр хангадаг.
 - A) Байгууллагын хамтын ажиллагааны систем
 - B) Удирдлагын мэдээллийн систем
 - C) Шийдвэр гаргалтад туслах систем
 - D) Дээрх бүгд зөв

10. Дараахаас аль нь системийн тухай ойлголтонд **ТОХИРОХГҮЙ** вэ?
- A) Эргэх холбоо нь системийн гүйцэтгэлтэй холбоотой өгөгдөл болон мэдээллүүд
 - B) Хяналт нь үнэн зөв гаралтыг бий болгохын тулд орц болон боловсруулалтын процессуудад шаардлагатай тохиргоонуудыг хийдэг.
 - C) Системийн эргэх холбоо нь систем өөрийн зорилгын төлөө зөв явж байгаа эсэхийг тодорхойлох хяналтын процессоос гарч ирсэн өгөгдлүүдийг монитор хийж, үнэлэх процесс
 - D) Орц нь системд орж боловсруулагдах элементүүдийг олж, цуглуулахтай холбоотой процесс
11. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа ямар төрлийн мэдээллийн СИСТЕМ СТРАТЕГИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ болох вэ?
- A) Зөвхөн ажил гүйлгээ боловсруулах систем
 - B) Зөвхөн удирдлагын мэдээллийн систем
 - C) Мэдээллийн систем нь стратегийг дэмждэггүй
 - D) Стратегийг дэмжиж буй бүх мэдээллийн систем
12. Бүх системүүдийн хувьд үндсэн үйл ажиллагаа буюу функц нь юу вэ?
- A) Нэг зорилготой, уялдаа холбоотой, хил хязгаартай
 - B) Оруулах, Боловсруулах, хянах
 - C) Эргэх холбоо, хяналт
 - D) Оруулах, боловсруулах, гаргах
13. Дараахаас аль нь мэдээллийн системийн эцсийн хэрэглэгч вэ?
- A) Менежерүүд
 - B) Нягтлан бодогчид
 - C) Үйлчлүүлэгчид
 - D) Дээрх бүгд зөв
14. Мэдээллийн технологи нь бүх төрлийн бизнест –ийн үр өгөөж, үр ашгийг дээшлүүлэхэд нь тусалдаг.
- A) Бизнес процесс
 - B) Удирдлагын шийдвэр гаргалт
 - C) Хамтын ажиллагаа
 - D) Өгөгдсөн хариултауд бүгд зөв
15. IBM шатар тоглох Deep Blue систем дэлхийн аварга Каспаровтой 6 удаа тоглож анх удаа нэг тоглолтод ялсан байна. Deep Blue ямар төрлийн Хиймэл оюун бэ?
- A) Artificial General Intelligence
 - B) Artificial Super Intelligence
 - C) Artificial Narrow Intelligence
16. Аль нь front-end хөгжүүлэлтэд ашиглагддаг технологи БИШ вэ?
- A) HTML
 - B) CSS
 - C) SQL
 - D) UI
17. Аналог өгөгдөл, мэдээллийг дижитал формат буюу компьютерт хадгалах, боловсруулах, дамжуулах боломжтой болгон хөрвүүлэхийг гэнэ
- A) Digitization
 - B) Digitalization
 - C) Digital transformation
 - D) Information system
18. Дараахаас аль нь хиймэл оюун ухааны дэд салбарт хамаарагдахгүй вэ?
- A) Машин сургалт (Machine learning)
 - B) Эх хэлний боловсруулалт (Natural language processing)
 - C) Роботууд (Robotics)
 - D) Танин мэдэхүйн сэтгэл зүй (Cognitive psychology)
 - E) Дээрх бүгд
19. Эх хэлний боловсруулалтын (natural language processing) салбар нь компьютерт хүний хэлийг ойлгох боломжийг олгоход чиглэдэг.
- A) Үнэн
 - B) Худал
20. Гүн сургалт (deep learning) нь мэдрэлийн сүлжээнд суурилсан машин сургалтын нэг төрөл юм.
- A) Үнэн
 - B) Худал
21. Чиглүүлэгчгүй сургалт (Unsupervised learning) гэдэг нь өгөгдөл тодорхойлоогүй, ангилаагүй машин сургалтын нэг төрөл юм.
- A) Үнэн
 - B) Худал

22. Тьюрингийн тест (turing test) нь компьютер хүнтэй ижил боломжтой эсэхийг тодорхойлоход хэрэглэгддэг.
- A) Үнэн
 - B) Худал
23. Блокчэйн технологийн үндсэн зорилго юу вэ?
- A) Өгөгдлийг аюулгүй байлгахын тулд
 - B) Итгэмжлэгдсэн зуучлагчгүйгээр хоёр хүний хооронд гүйлгээ хийхийг идэвхжүүлэх
 - C) Мэдээлэл боловсруулах хурдыг сайжруулах
 - D) Онлайн тоглоомд ашиглах дижитал жетон (tokens) үүсгэх
 - E) Аль нь ч биш
24. Дараахаас аль нь блокчэйн технологийн онцлог шинж биш вэ?
- A) Ил тод байдал
 - B) Өөрчлөгдөхгүй байдал
 - C) Төвлөрлийг багасгах
 - D) Төвлөрлийг нэмэх
 - E) Дээрх бүгд
25. Дараахаас аль нь блокчэйн технологийн онцлог шинж БИШ вэ?
- A) Ил тод байдал
 - B) Өөрчлөгдөхгүй байдал
 - C) Төвлөрлийг багасгах
 - D) Нууцлал
 - E) Дээрх бүгд
26. Блокчейн дээр бичигдсэн гүйлгээг сүлжээнд нэмсний дараа өөрчлөх, устгах боломжгүй.
- A) Үнэн
 - B) Худал
27. Чиглүүлэгчгүй сургалтын (unsupervised learning) үндсэн зорилго юу вэ?
- A) Өгөгдлийг өөр өөр ангилалд ангилах
 - B) Ирээдүйн үйл явдлын үр дүнг урьдчилан таамаглах
 - C) Тодорхой зааварчилгаагүйгээр өгөгдөл дэх хэв маягийг (pattern) сурах
 - D) Тодорхойлсон өгөгдөл бүхий загварыг (model) сургах
 - E) Аль нь ч биш
28. Чиглүүлэгтэй сургалтын (supervised learning) алгоритмын жишээ аль нь вэ?
- A) K-means clustering
 - B) Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ (Principal Component Analysis)
 - C) Random Forests
 - D) Логистик регресс (Logistic Regression)
 - E) Аль нь ч биш
29. Дундын дэвтэр (shared ledger) гэж юу вэ?
- A) Нэг аж ахуйн нэгж өөрсдийн бүртгэлд ашигладаг дэвтэр
 - B) Дундын дэвтэр гэдэг нь интернэтэд байгаа хэн бүхэнд хандах боломжтой дэвтэр
 - C) Дундын дэвтэр гэдэг нь гүйлгээний мэдээллийг хадгалсан баталгаажсан өгөгдлийн сан
30. Хиймэл оюун ухаан болон машин сургалт хоорондоо ямар ялгаатай вэ?
- A) Ямар ч ялгаа байхгүй
 - B) AI бол машин сургалтын дэд хэсэг (subset) юм
 - C) Машины сургалт нь хиймэл оюун ухааны дэд хэсэг юм
 - D) Хиймэл оюун ухаан гэдэг нь хүн шиг сэтгэж чаддаг машинуудыг хэлдэг бол машин сургалт гэдэг нь өгөгдөлөөс суралцах чадварыг хэлдэг.
 - E) Аль нь ч биш
31. Дараахаас аль нь эх хэл боловсруулах (natural language processing) програмын жишээ вэ?
- A) Яриа таних (speech recognition)
 - B) Машины орчуулга (Machine translation)
 - C) Дээрх бүгд
 - D) Аль нь ч биш
32. Байгууллага, хувь хүн өөрийн хэрэгцээнд зориулан ашиглах зориулалттай үүлэн технологийн хэлбэр аль нь вэ?.
- A) Хаалттай
 - B) Нээлттэй
 - C) Холимог
 - D) Client/Server

33. Боловсруулалтын хүчин чадал 12-18 сарын хугацаанд 2 дахин нэмэгдэж байна.
- A) Moore's law
 - B) Butter's law
 - C) Kryder's law
34. Дурын этгээд ашиглах боломжтой үүлэн технологийн хэлбэр аль нь вэ?.
- A) Хаалттай
 - B) Нээлттэй
 - C) Холимог
 - D) Client/Server
35. Зөвхөн бусдыг ойлгож, мэдрэхээс гадна өөрийн гэсэн сэтгэл хөдлөл, итгэл үнэмшилтэй байх боломжтой талаар онолын түвшинд судлагдаж буй хиймэл оюун ухааны системийн төрөл аль нь вэ?.
- A) Reactive Machines
 - B) Limited memory
 - C) Theory of mind
 - D) Self-aware AI
36. Интернетийн сүлжээгээр хандан ашиглах боломжтой техник хангамж, програм хангамж, сүлжээ, сервер, өгөгдлийн хадгалалт, үйлчилгээнүүд нь юм.
- A) Утасгүй сүлжээ
 - B) NFC – Near Field Communication
 - C) Үүлэн технологи
 - D) Client/Server
37. Өгөгдөл үүсэх, дамжуулах хурд нь их өгөгдлийг илэрхийлэх шинж чанар юм.
- A) Velocity
 - B) Value
 - C) Veracity
 - D) Variety
38. Их өгөгдлийн илүү нарийвчлал өндөртэй, итгэл даахуйц шинж чанарыг аль нь илэрхийлдэг вэ?.
- A) Volume
 - B) Value
 - C) Variety
 - D) Veracity
39. Их өгөгдөлтэй ажиллах, өгөгдлийг үр дүнтэйгээр хадгалах, ашиглах боломж олгодог нээлттэй эхийн технологи аль нь вэ?.
- A) Hadoop
 - B) MS SQL
 - C) Database
 - D) Data mining
40. Машин сургалт нь орчны өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэн эерэг, сөрөг эргэх холбоог хүлээн авч боловсруулалт хийх замаар суралцдаг бол төрөл юм.
- A) Supervised learning
 - B) Unsupervised learning
 - C) Deep learning
 - D) Reinforcement learning

ЯВЦЫН СОРИЛ 1: ХАРИУЛТЫН ХУУДАС

Test No.	1	2	3	4	5	6	7	8	9	10
Answer										

Test No.	11	12	13	14	15	16	17	18	19	20
Answer										

Test No.	21	22	23	24	25	26	27	28	29	30
Answer										

Test No.	31	32	33	34	35	36	37	38	39	40
Answer										